



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/504

Булган сум

**Карьер ашиглах түр зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1, Засгийн Газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам”-ын 5.3, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хутаг-Өндөр сумын төвийн хатуу хучилттай 0,8 км авто замын засвар шинэчлэлийн ажил”-д шаардагдах шороон орд, чулууны карьерын байршлын координатыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд карьер ашиглах түр зөвшөөрлийг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зураг, төсвийн дагуу гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөхийг “Энх-Алтаргана” ХХК (А.Энхжаргал)-д олгосугай.

3.Чулуун карьер түр ашиглуулах гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж нөхөн сэргээлтийн ажлыг чанарын өндөр түвшинд хийлгэж хүлээн авч ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д үүрэг болгосугай.

4.Тус компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр), Татварын газрын дарга (Д.Лхагвасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010866

Аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар  
сарын 12-ны өдрийн 1508 дугаар  
захирамжийн хавсралт

Шороон орд, чулуун карьерын байршил

№	Нэр	Ажлын зургийн байршил	Координат		
			№	Уртраг	Өргөрөг
1	Карьер 1	Хутаг-Өндөр сум 4-р баг	1	102° 49' 49.9"	49° 23' 22.7"
			2	102° 49' 50.0"	49° 23' 21.4"
			3	102° 49' 48.4"	49° 23' 21.6"
			4	102° 49' 48.4"	49° 23' 22.6"
2	Карьер 2	Хутаг-Өндөр сум 1-р баг	1	102° 39' 07.5'	49° 25' 12.7"
			2	102° 39' 07.6"	49° 25' 11.2"
			3	102° 39' 06.2"	49° 25' 11.5"
			4	102° 39' 06.4"	49° 25' 12.4"